



Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 07 сарын 25 өдрийн
А/59 дугаар тушаалын 1 хавсралт

АНХАН ШАТНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн статистик мэдээллийн талаар авах зарим арга хэмжээ” А/611 дугаар тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагуудад хөтлөгдөх анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягт хөтлөх, мэдээ тайлан гаргах, мэдээлэх журмыг хэрэгжүүлэх,
- 1.2 Монгол Улсын Статистикийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасныг мөрдлөг болгон хэрэгжүүлж, бүх төрлийн албан ёсны анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягуудын хөтлөлтийг статистикийн үйл ажиллагааны зарчмын дагуу хөтлөн явуулах,
- 1.3 Эрүүл мэндийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт дурдсан асуудлаар магадлагааг Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1999 оны “Журам, дүрэм, маягтын загвар бэлтгэх тухай /Эмнэлгийн магадлагаа гаргах журам/ А/243 дугаар тушаал, Монгол улсын хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/30 дугаар тушаалуудыг мөрдлөг болгон хэрэгжүүлж, эмнэлгийн магадлагаа болон эмнэлгийн хуудсыг гаргах ба олгох,
- 1.4 Монгол хэлний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх хэсэгт заасныг мөрдлөг болгон хэрэгжүүлж, эмнэлгийн тусламж, үйлчилгээнд өвчний түүх хөтлөх, онош тавих, оношилгоо, шинжилгээний хариу зэрэг эмнэлгийн тусламж, үйлчилгээний бүх төрлийн албан хэрэг хөтлөлтийг монгол хэлээр хөтлөн эмнэлгийн тусламж үйлчилгээний мэргэжлийн болон техникийн өвөрмөц нэр томъёо, үг хэллэгийн ойлгомжтой байдлыг хангах үүднээс англи, орос хэлний аль нэгээр орчуулгын хамт ашиглах,

Хоёр. Журмын зорилго, хамрах хүрээ

- 2.1 Эмнэлгийн мэргэжилтнүүд нь өдөр тутам хийгдэж байгаа эмнэлгийн үзлэг, эмчилгээ, сувилгаа зэрэг аливаа тусламж, үйлчилгээг зориулалтын маягтанд статистикийн албан ёсны үйл ажиллагааны зарчмыг баримтлан хөтлөхөд энэхүү анхан шатны маягт хөтлөх журмын зорилго оршино.
- 2.2 Сэргээн засах төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд дагаж мөрдөнө.

Гурав. Ерөнхий шаардлага

- 3.1 Сэргээн засах төв нь үйлчлэх хүрээний хүн амын өвчлөл, эмнэлгийн тусламж, үйлчилгээний тоон мэдээнд тулгуурласан эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээний судалгаатай байна.
- 3.2 Сэргээн засах төв нь тухайн байгууллагын хөгжлийн төлөвлөлт, санхүүжилт, бүтэц, үйл ажиллагаанд статистик тоон мэдээллийг тусган ажиллана.
- 3.3 Сэргээн засах төв нь тоон мэдээллийн алдаанаас сэргийлж, албан ёсны статистик мэдээллийг үйл ажиллагаанд хэрэглэнэ.
- 3.4 Сэргээн засах төв нь тусламж, үйлчилгээнд заавал мөрдөх анхан шатны бүртгэлийн болон тайлангийн маягтын нэгдсэн судалгаатай байна
- 3.5 Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд нэн шаардлагатай боловч Эрүүл мэндийн сайдын 2019 оны “Эрүүл мэндийн статистик, мэдээллийн талаар авах зарим арга хэмжээ” А/611 дугаар тушаал болон бусад тушаал журмаар батлагдаагүй анхан шатны бүртгэлийн маягтуудын хэрэгцээ шаардлагыг Статистик бүртгэл мэдээллийн ажилтан үнэлж, төвийн даргаар баталгаажуулан ажиллах
- 3.6 Эмнэлгийн байгууллага нь эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дугаар тушаал болон эрүүл мэндийн төвийн даргаар баталгаажсан анхан шатны бүртгэлийн маягтаар бүрэн хангана.

Дөрөв. Анхан шатны маягт бүртгэл

- 4.1 Эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой бүх төрлийн анхан шатны бүртгэл маягыг бичмэл хэлбэрээр хөтлөхдөө Монгол хэлээр зөв, гаргацтай, маягтан дээрх зааврын дагуу бүрэн гүйцэд, балны өнгө холихгүй хөтөлнө.
- 4.2 Амбулаторийн картыг хөтлөхдөө нарийн мэргэжлийн эмч үйлчлүүлэгчийн гол, бодит зовируудыг дараалуулан бичнэ. Бодит үзлэгийг ерөнхий, хэсэгчилсэн, эрхтэн тогтолцоогоор үзэж, тухайн эмч мэргэжлийн онцлогт тохируулан хэсэг газрын үзлэгийг бичнэ.
- 4.3 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь үзлэгийн бүртгэл АМ-1Б, сэргээн засах эмчилгээний бүртгэл АМ-25Б, хяналтын карт АМ-11, осол гэмтлийн мэдээлэх хуудас, маягтуудыг цахим хэлбэрээр бүртгэнэ.

Тав. Эмнэлгийн магадлагаа, эмнэлэгт өвчтөн илгээх хуудас

- 5.1 Статистик, мэдээллийн кабинет нь эмнэлэгт өвчтөн илгээх хуудас, эмнэлгийн магадлагааны маягт болон тэдгээрийг бүртгэх хуудсыг олгохдоо дугаарлан олгоно.

- 5.2 Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас, эмнэлгийн магадлагаа нь засваргүй, ойлгомжтой, тодорхой дугаар, огноотой бичигдсэн байх ба түүн дээр магадлагаа гаргагч эмч, эмчилгээний тасгийн эрхлэгч нар албан тушаал, овог нэрээ бичиж, гарын үсэг зурж, байгууллагын тамга тэмдэг дарж баталгаажуулсан байна.
- 5.4 Эмнэлгийн магадлагаа олгосон тухай бүртгэлийн хуудсыг эмч бүртгэх ба магадлагааны дугаар, бүртгэх хуудасны дугаар тохирч байна.
- 5.5 Эмнэлэгт өвчтөн илгээх хуудсыг эмч бүртгэх ба өвчтөн илгээх хуудасны дугаар, бүртгэх хуудасны дугаар тохирч байна.
- 5.6 Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас, эмнэлгийн магадлагааг гаргах, олгох үйл ажиллагаа нь эмнэлгийн нууц болон эмчийн ёс зүйн хэм хэмжээнд нийцсэн байвал зохино.
- 5.7 Статистик мэдээллийн ажилтан нь эмнэлэгт өвчтөн илгээх хуудас, эмнэлгийн магадлагаа олгосон тухай бүртгэлийн хуудсыг улирал тутам нэгтгэн дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг байгууллагын удирдах албан тушаалтанд тайлагнана.

Зургаа. Хүлээлгэх хариуцлага

- 6.1 Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд буруутай этгээдэд холбогдох хууль, тушаал, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 07 сарын 27 өдрийн
459 дугаар тушаалын 2 хавсралт

Анхан шатны бүртгэлийн маягтын жагсаалт

9020010653 6133733

- 1.1. Өвчний түүх СТ-1 /Эмчлэгч эмч/
- 1.2. Эмчлүүлэгчийн хэрэглэсэн эм, эмнэлгийн хэрэгслийн хуудас СТ-1 Хавсралт-1 /Сувилагч, эмч/
- 1.3. Эмчлүүлэгчийн амин үзүүлэлт хянах хуудас СТ-1,2 хавсралт-2 /Сувилагч/
- 1.4. Сувилагч эмчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлэх хуудас СМ-1 Хавсралт-11 /Сувилагч/
- 1.5. Сувилгааны тэмдэглэл СМ-2 Хавсралт-12 /Сувилагч/
- 1.6. Өвдөлтийг хянах хуудас СМ-4 Хавсралт-14 /Сувилагч/
- 1.7. Эмчлүүлэгчийн сувилалд хүлээн авсан бүртгэл СТ-13А /Сувилагч/
- 1.8. Яаралтай тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн бүртгэл СТ-13Б /Сувилагч/
- 1.9. Эмчлүүлэгсдийн өдөр тутмын тооцооны бүртгэл СТ-14 /Статистик, мэдээллийн ажилтан/
- 1.10. Эмийн захиалгын түүвэр СТ-27 /Сувилагч/
- 1.11. Тусгай хог хаягдлын устгалын бүртгэл СТ-28 / Хог хаягдал хариуцсан ажилтан/
- 1.12. Тусгай хог хаягдлын бүртгэл СТ-29 /Хог хаягдал хариуцсан ажилтан/
- 1.13. Эмнэлгийн зөөлөн эдлэлд хийсэн халдваргүйтгэл, угаалга ариутгалд хүлээн авч, олгосон бүртгэл СТ-30 /Ариутгагч/
- 1.14. Ариутгалд багаж, материал хүлээн авч олгосон бүртгэл СТ-31 /Ариутгагч/
- 1.15. Яаралтай тусламжийн хуудас /Хүүхдийн/ СТ-32Б /Сувилагч/
- 1.16. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс татгалзсан тухай мэдүүлэг СТ-1 хавсралт-12 /Эмчлэгч эмч/
- 1.17. Халдварт өвчний хамшинж, сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудас АМ-2А /Эмчлэгч эмч/
- 1.18. Нас барсан тухай эмнэлгийн гэрчилгээ АМ-07 /Эмчлэгч эмч/
- 1.19. Эмнэлгийн магадлагаа АМ-8 /Эмчлэгч эмч/
- 1.20. Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас 13-А /Эмчлэгч эмч/
- 1.21. Эмнэлгээс өвчтөн илгээх хуудас АМ-13Б /Эмчлэгч эмч/
- 1.22. Эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэлийн маягт АМ-13В /Хөтөч сувилагч/
- 1.23. Амбулаториор эмчлүүлэгчидийн карт /Эмчлэгч эмч/
- 1.24. Шинжилгээнд явуулах бичиг АМ-21А/Б /Эмчлэгч эмч/

- 1.25. Сэргээн засах эмчилгээний карт AM-25A /Сэргээн засах эмчилгээний эмч/
- 1.26. Сэргээн засах эмчилгээний бүртгэл AM-25Б /Сэргээн засах эмчилгээний сувилагч/
- 1.27. Бариа засал эмчилгээний карт AM-29Б /Бариа эмч, сувилагч/
- 1.28. Өдрийн эмчилгээний бүртгэл /Хүүхэд/ AM-30А /Эмчлэгч эмч/
- 1.29. Осол гэмтлийн тохиолдлыг бүртгэх хуудас AM-33 /Эмчлэгч эмч/
- 1.30. Хөдөлгөөн засал эмчилгээний үнэлгээний хуудас AM-34 /Хөдөлгөөн засалч/
- 1.31. Хөдөлмөр заслын үнэлгээний хуудас AM-35 /Хөдөлмөр засалч/
- 1.32. Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг мэдээлэх бүртгэл AM-36 /Статистик, мэдээллийн ажилтан/
- 1.33. Сэргээн засах эмчийн үзлэг /Сэргээн засах эмчилгээний эмч/

Хоёр. Сар, улирлын мэдээ тайлан

- 2.1. Сэргээн засах төв нь бүртгэгдсэн амбулатори, стационарын тусламж, үйлчилгээний үзүүлэлтүүдийг улсын тайлан маягт ЭМТ-501.1-ын дагуу сар бүр цахим хэлбэрээр мэдээлнэ.
- 2.2. Сэргээн засах төв нь сэжигтэй болон онош нь батлагдаагүй өвчлөлийг тухайн сарын мэдээнд оруулалгүй, онош баталгаажсаны дараа мэдээлнэ.
- 2.3. Сарын мэдээг тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгож авна.
- 2.4. Сарын мэдээний нэгтгэлийг дараа сарын 2-ны дотор багтаан Нийслэлийн эрүүл мэндийн газарт мэдээлнэ.
- 2.5. Сувилалд хэвтэн эмчлүүлэгчдийн цахим мэдээний санг өдөр, сар, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны өдрийн дотор бүрдүүлнэ.
- 2.6. Эрүүл мэндийн бүртгэл тайлангийн программд хүн амын халдварт болон халдварт бус өвчний тохиолдол бүрийг шивж, цахим мэдээний санг үүсгэнэ.
- 2.7. Сэргээн засах төв нь халдварт болон халдварт бус өвчний мэдээ, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн цахим мэдээний санг өдөр, сар, улирлаар нэгтгэж, тайлан гаргах ба улирлын тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор бүрдүүлсэн байна.